



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 02 өдөр


Дугаар 0/249

Ховд

“Тэргүүний” сум, баг, байгууллагыг шагнаж
урамшуулахад хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1. Аймгийн Засаг даргын Тамгын газраас сум, албан байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, аймгийн Засаг даргын Тамгын газрын саналыг үндэслэн нэр бүхий 4 сум, 8 баг, 8 албан байгууллагыг байр эзлүүлэн “Хүндэт өргөмжлөл”, мөнгөн шагналаар шагнах 9,700,000 төгрөг (есөн сая долоон зуун мянга)-ийг хавсралтаар баталсугай.
- 2. Урамшуулалд зарцуулах 9,700,000 төгрөг (есөн сая долоон зуун мянга)-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ч.Багдал)-д зөвшөөрсүгэй.
- 3. Шалгарсан сум, баг, албан байгууллагын дарга нарыг сарын үндсэн цалингийн 50% (тавин хувь)-аар тус тус шагнаж урамшуулахыг тухайн сум, байгууллагын дарга, нягтлан бодогч нарт зөвшөөрсүгэй.
- 4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхболд)-д үүрэг болгосугай.


 ДАРГААС Б.ДУГЭРЖАВ
 2022.05.02



Аймгийн засаг дарга Н. 2022 оны
05 дугаар сарын 29-ны өдөр /
A/249 дугаар захирамжийн
гавсрагт

СУМ, БАГ, БАЙГУУЛЛАГУУДЫН БАЙР ЭЗЭЛСЭН БАЙДАЛ

2022.04.29

Д/д	Сум, баг, байгууллагын нэр	Эзэлсэн байр	Мөнгөн дүн
Сум			
1	Эрдэнэбүрэн сум	Тэргүүн байр	1000000
2	Цэцэг сум	Шилдэг сум	500000
3	Жаргалант сум	Шилдэг сум	500000
4	Манхан сум	Шилдэг сум	500000
	ДҮН		2500000
Баг			
1	Булган сумын Баянгол баг	Шилдэг баг	300000
2	Дуут сумын Хөхбэлчир баг	Шилдэг баг	300000
3	Жаргалант сумын Алагтолгой баг	Шилдэг баг	300000
4	Жаргалант сумын Бугат баг	Шилдэг баг	300000
5	Манхан сумын Төгрөг гол баг	Шилдэг баг	300000
6	Мөнххайрхан сумын Борт баг	Шилдэг баг	300000
7	Мянгад сумын Чацаргант баг	Шилдэг баг	300000
8	Ховд сумын Дунд Ус баг	Шилдэг баг	300000
	ДҮН		2400000
Албан байгууллага			
1	Эрүүл мэндийн газар (Зоонозын өвчин судлалын албатай)	Тэргүүн байр	1000000
2	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар	Шилдэг байгууллага	300000
3	Стандарт, хэмжил зүйн хэлтэс	Шилдэг байгууллага	300000
4	Нийгмийн даатгалын хэлтэс	Шилдэг байгууллага	300000
5	Зэвсэгт хүчний 123 дугаар анги	Шилдэг байгууллага	300000
6	Ус цаг уур, орчны шинжилгээний төв	Шилдэг байгууллага	300000
7	Онцгой байдлын газар	Шилдэг байгууллага	300000
8	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар	Шилдэг байгууллага	300000
	ДҮН		3100000
	НИЙТ ДҮН		8.000.000

МАТЕРИАЛЫН ҮНЭ

Д/д	Материалын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл	20	50000	1000000
2	Батламж	20	35000	700000
	НИЙТ ҮНЭ			1.700.000

-оОо-